



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/204

Бор-Өндөр сум

[Ерөнхий боловсролын "Бор-Өндөр" сургуулийн
хүүхэд хамгааллын баг томилох тухай]

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалт, Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн А/453 дугаар тушаалын 2 дугаар зүйлийн 2.1, 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймаг Бор-Өндөр сумын Ерөнхий боловсролын "Бор-Өндөр" сургуулийн "Хүүхэд хамгааллын баг"-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Багийн ахлагч:

Ц.Ганхүү	Сургуулийн захирал
----------	--------------------

Нарийн бичиг:

Ч.Минжмаа	Нийгмийн ажилтан
-----------	------------------

Гишүүд:

Э.Анударь	Нийгмийн ажилтан
Б.Цагаанбаатар	Сургалтын менежер
Г.Сийлэгмаа	Сургалтын менежер
Э.Азжаргал	Сургуулийн эмч
Х.Уранчимэг	Дотуур байрны багш
Х.Энхзул	Сэтгэл зүйч


2. Бор-Өндөр сумын Ерөнхий боловсролын "Бор-Өндөр" сургуулийн хүүхэд бүрийг сургууль болон дотуур байр, гэр бүлийн орчинд бие махбодын шийтгэл, сэтгэл санааны болон үе тэнгийн дарамт, гэмт хэрэг зөрчил, хорт зуршилд өртөхөөргүй байх нөхцөлийг бүрдүүлэн хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан батлуулж ажиллахыг хүүхэд хамгааллын багт даалгасугай.

3. Үйл ажиллагааны явцыг эцэг, эх, асран хамгаалагч, багш, ажилчид, сурагчдадаа тайлагнаж байх, хагас, бүтэн жилээр хийсэн ажлын тайланг Боловсрол шинжлэх ухааны газрын хүүхэд хамгааллын мэргэжилтэнд хүргүүлж ажиллахыг Бор-

2.//

Өндөр сумын Ерөнхий боловсролын "Бор-Өндөр" сургуулийн "Хүүхэд хамгааллын баг"-ийн ахлагч, сургуулийн захирал (Ц.Ганхүү)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ